НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.01.31 № 03/99

танай ________ -ны № ________ -т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Тус газраас 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр зарласан НХААГ/20240101133 дугаартай Эрдэнэтолгой, УС-15 орчмын үерийн хамгаалалтын барилга байгууламж, хөрсний усны түвшин доошлуулах шинэ шугам (БЗД, 8 дугаар хороо)-ын ажлын тендер шалгаруулалтын тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-т заасан шалгуур үзүүлэлтийг захиалагчаас дараах байдлаар нэмэлт, өөрчлөлт оруулж хүргүүлж байна. Үүнд:

| | |
|---|---|
| **ТШЗ 19.2** | Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримтыг нотлох баримт бичиг;<br>1. Ажил гүйцэтгэх үе шатны ажлын хуваарийг баталгаажуулан ирүүлэх ба ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр байна.<br>2. Төсвийг ажлын даалгаврын дагуу тооцож эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулан ирүүлнэ.<br>3. Энэ гаргасан ажлын тоо хэмжээг сонгон шалгаруулалтын үндсийг тавих үүднээс урьдчилан тооцож гаргасан, гүйцэтгэгч өгөгдсөн тоо хэмжээг газар дээр нь шалгаж дутуу болон орхигдсон ажлын тоо хэмжээг нэмж оруулж төсөвт тусгаж саналаа ирүүлэх,<br>Өөрчлөлт хийгдсэн зураг төсвийн үнэ болох 8,000,000 (найман сая) төгрөгийг төсөвт тусгаж ирүүлэх<br>4. Ажлын талбайтай танилцсан тэмдэглэлийг фото зургийн хамт ирүүлнэ.<br>5. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан зураг төсөл, техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.<br>6. Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газраас баталсан UCS 0501A, UCS 0501B, UCS 0501C стандарт болон захиалагчаас ирүүлсэн ажлын даалгаварт заасан |

| | |
|---|---|
| | стандартын дагуу ажил гүйцэтгэх тухай мэдэгдэл ирүүлэх.<br>Тус газрын www.standard.ub.gov.mn сайтны үйлчилгээ цэсний хотын стандарт, батлагдсан баримт бичгүүд хэсгээс танилцах боломжтой.<br>7. Эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлын хангах байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай ногоон орчныг бүрдүүлэх тухай мэдэгдэл ирүүлнэ.<br>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт (Adobe PDF) шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.<br>ӨХ-д шаардсан материалуудын дутуу болон аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. |

Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцно.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэж ирүүлнэ үү.

Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
Удирдлага
Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Даваадорж Батцэцэг
2024.01.31 15:08